



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
дөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцэх
асуудалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэгийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/30 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2021 оны 01/763, 01/764 дүгээр албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 14 цагт товлогдсон дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулсугай.

1.1 Хурлын хороод байгуулж, ажиллах журмыг батлах тухай

1.2 Дүүргийн хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай

1.3 Дүүргийн 2020 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

1.4 Дүүргийн 2021 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.5 Дүүргийн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2. Ээлжит хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ч.Мэндсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАЯР

1130100062